Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 880,345.6 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 595,818.4 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 21,279.1 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 263,248.1 мянган төгрөг байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 298,496.5 мянга, эцсийн үлдэгдэл 296,674.3 мянган төгрөг болж 1,822.2 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	-	1,714.7	1,714.7
Татаас санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	103,748.0	78,000.4	-25,747.6
Хувь хүмүүсээс авах авлага	244.3	-	-244.3
Хувь хүмүүст олгосон зээл	194,504.2	216,959.2	22,455.0
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл	-	-	-
<b>Дүн</b>	<b>298,496.5</b>	<b>296,674.3</b>	<b>-1,822.2</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 12,5 хувь буюу 36,989.2 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 60,7 хувь буюу 179,970.0 мянган төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн авлага, 0,72 хувь буюу 2,146.9 мянган төгрөг нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын авлага, 26,1 хувь буюу 77,568.2 хувь нь Засаг даргын тамгын газрын авлага байна.

#### Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	103,315.8	77,568.2	-25,747.6	26,3
ИТХ	432.2	2,146.9	1,714.7	0,6
ОНХС	37,233.4	36,989.2	-244.3	12,5
СХС	157,515.0	179,970.0	22,455.0	60,6
<b>НИЙТ ДҮН</b>	<b>298,496.5</b>	<b>296,674.3</b>	<b>-1,822.2</b>	<b>100,0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 157,515.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 1 аж ахуйн нэгж байгууллага, 4 иргэнд 70,000.0 мянган төгрөгийн зээл олгосон бөгөөд 47,545.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 179,970.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

ЗДТГ-ын зээл нь Орон нутгийн өмчийн газраас өгсөн шийдвэрийг үндэслэн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй байсан 29,700.1 мянган төгрөгийн үнэтэй моторыг авлагаар тусгасан, мөн 47,868.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны авлага байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 45,052.8 мянга, эцсийн үлдэгдэл 70,431.2 төгрөг болж, 25,378.4 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1,581.8	1,581.8	-
Эм боох материал	-	-	-
Бичиг хэргийн материал	1,038.0	1,745.0	707.0
Аж ахуйн материал	273.0	6,516.0	6,243.0
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	-	-	-
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	42,159.9	51,159.9	9,000.0
Мал амьтад	-	9,428.4	9,428.4
Нөөцийн бараа	-	-	-
<b>Дүн</b>	<b>45,052.7</b>	<b>70,431.1</b>	<b>25,378.4</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 70,431.1 мянган төгрөг болж өмнөх оноос 25,378.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 707.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 6,243.0 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 9,000.0 мянган төгрөг, мал амьтад 9,428.4 мянган төгрөг байна.

#### Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,237.5	3,342.5	105.0	4.9
ЗДТГ	41,815.2	67,008.6	25,193.4	95.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>45,052.7</b>	<b>70,431.1</b>	<b>25,378.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 102,855.7 мянган төгрөгийн бараа материалын 78,556.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 24,299.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 77,477.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	102,855.7	Хасагдсан	77,477.3
Худалдан авсан	78,556.3	Худалдсан, зарцуулсан	77,477.3
Хандиваар	24,299.4	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-
Шилжүүлсэн авсан	-	шилжүүлсэн	-
бусад	-	бусад	-

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,876,731.2 мянга, эцсийн үлдэгдэл 2,837,220.4 мянган төгрөг болж 960,489.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	1,833,743.8	2,786,876.8	953,132.9	97,9
Барилга байгууламж, орон сууц	2,961,435.5	2,872,267.3	-89,168,2	40,2
Тээврийн хэрэгсэл	166,604.8	305,464.8	138,860,0	7,6
Машин тоног төхөөрөмж	247,632.9	321,262,7	73,629,8	20,6
Тавилга эд хогшил	81,806,0	104,545,0	22,739,0	2,0
Дуусаагүй барилга байгууламж	-	-	-	0.0
Номын фонд	24,508,7	24,508,7	-	0.0
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	42,987.3	50,343.6	7,356.,	2,1
Программ хангамж	1,075,0	1,075,0	0	0,1
Бусад биет бус хөрөнгө	42,694,0	50,123,6	7,429,6	2
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,876,731.2</b>	<b>2,837,220.4</b>	<b>960,489.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,876,731.2 мянга, эцсийн үлдэгдэл 2,837,220.4 мянган төгрөг болж, 960,489.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	10,100.3	19,283.2	9,182.9	32,1
ЗДТГ	1,866,630.9	2,817,937.2	951,306.3	67,9
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,876,731.2</b>	<b>2,837,220.4</b>	<b>960,489.2</b>	<b>100,0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 960,489.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 77,1 хувь буюу 770,442.9 мянган төгрөгийг ЗДТГ-ийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгө голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	<b>1,131,510.4</b>	Хасагдсан	953,020.2
Худалдан авсан	102,627.4	Худалдсан	
Хандиваар	25,910.0	Акталсан	953,020.2
Шилжүүлэн авсан	781,574.6	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-
Бусад	221,398.4	Бусад	-

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 76,0 мянган төгрөг эцсийн үлдэгдэл 5,994.0 мянган төгрөг болж 5,918.0 мянган төгрөгөөр өссөн.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	76,0	5,994,0	5,918,0	98.7
1. Ажиллагсадтай холбогдсон өглөг	76,0		-76.0	1.3
2. Бусад өглөг		5,994,0	5,918,0	98.7
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5,994,0</b>	<b>5,918,0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөрийн 5,994.0 төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь ЗДТГ-ын өвс тэжээлийн өглөг байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	76,0	5,994.0	5,918.0	100,0
ДҮН	76.0	5,994.0	5,918.0	100,0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 697,830.0 мянга, эцсийн үлдэгдэл 705,282.6 мянган төгрөг болж, 7,429.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	697,830.0	705,282.6	7,429.6	17,3
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,072,028.4	3,269,027.4	1,196,999.1	80,1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,567.5	104,367.4	13,200.1	2,6
<b>Дүн</b>	2,887,448.8	4,078,677.4	1,191,228.6	100,0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,429.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.16-ны өдрийн хуралдаанаар 13/69 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг анх 275,550.0 мянга, хүү торгуулийн орлогыг 8,000.0 мянга, нийт 283,550.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.07-ний өдрийн 17/86 дугаар тогтоолоор татварын орлогыг 12,550.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	288,100.0	445,925.1	157,825.1	154,8
ЦХТА орлого /суутган/	138,050.0	155,988.7	17,938.7	113,0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,600.0	2,986.2	1,386.2	186,6
Бууны татвар	2,550.0	2,722.0	172.0	106,7
ИОТХ	18,000.0	19,702.6	1,702.6	109,4
Улсын тэмдэгийн хураамж	1,500.0	293.0	-1,207.0	-19,5
Хадгаламжийн хүүгийн орлого	48,900.0	45,351.4	-3,548.6	-92,7
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	5,090.0	2,090.0	169,7
Малд ногдуулах албан татвар	60,000.0	60,977.1	977.1	101,6
Ус ашигласны төлбөр	-	-	-	-
Газрын төлбөр	3,000.0	1,553.5	-1,446.5	-51,8

**Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Газрын дуудлага худалдааны орлого	3,000.0	-	-3,000.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.0	5,100.6	-2,899.4	-63,7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	146,160.0	146,160.0	-
ТТАМАТөлбөр	500.0	-	-500.0	-
Бусад татвар	-	-	-	-
<b>2.Татварын бус орлого</b>	<b>8,000.0</b>	<b>21,828.1</b>	<b>13,828.1</b>	<b>272,8</b>
<b>2.1.Хүү торгуулийн орлого</b>	<b>8,000.0</b>	<b>21,828.1</b>	<b>13,828.1</b>	<b>272,8</b>
<b>Нийт дүн</b>	<b>296,100.0</b>	<b>467,753.2</b>	<b>171,653.2</b>	<b>158,0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 158,0 хувь буюу 171,653.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 17,938.7 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 1,386.2 мянга, бууны татвар 172.0 мянга, иргэний орлого тодорхойлох татвар 1,702.6 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 2,090.0 мянга, малд ногдуулах албан татвар 977.1 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 146,160.0 мянга, хүү торгуулийн орлого 13,828.1 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин улсын тэмдэгтийн хураамж 1,207.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 3,548.6 мянга, газрын төлбөр 1,446.5 мянга, газрын дуудлага худалдааны орлого 3,000.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,899.4 мянга, ТТАМАТөлбөр 500.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1751,3 мянган төгрөгийн орлого оруулж 751,3 мянган төгрөгөөр давуулсан байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2348801,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1997193,4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 963998,4 мянган төгрөгийг урсгал зардал зарцуулж 1033195,0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт №9. Зардлын дүн /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>Баян-Өндөр сумын Засаг дарга</b>	<b>2348801,2</b>	<b>1997193,4</b>	<b>351607,8</b>	<b>85.0</b>
2	<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>	<b>112807,3</b>	<b>94804,7</b>	<b>18002,6</b>	<b>84.0</b>
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2500,0	2195,2	304,8	87,8
4	<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>630625,9</b>	<b>573844,6</b>	<b>56781,3</b>	<b>91.0</b>
5	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	76831,8	72542,1	4289,6	94.0
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1000,0	400,0	600,0	40.0
7	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	0	0	0	0.0
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	33550,0	19758,5	13791,5	59.0
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	33186,0	31196,0	1990,0	94.0
10	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	8000,0	7593,8	406,2	95.0
11	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа				

12	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	31675,7	29229,7	2446,0	92,2
13	71702 Соёл урлаг	29550,5	21669,9	7880,6	73,3
14	71801 Сургуулийн өмнөх боловсрол	46006,1	43441,2	2564,9	94,4
15	71802 Ерөнхий боловсрол	132796,1	131008,3	1787,8	98,6
16	70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	1274180,6	1033195,0	240985,6	81
17	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	523904,1	506635,3	17268,8	97
18	83402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	4865,5	4865,5	0	100
19	83403 ОНХС ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	69107,9	69107,9	0	100
20	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	60000,0	59058,5	941,5	98
21	83406 ОНХС -бусад	76683,3	76683,3	0	100
22	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	91159,0	70000,0	21159,0	76,8
	<b>Нийт дүн</b>	<b>2348801,2</b>	<b>1997193,4</b>	<b>351607,8</b>	<b>85,0</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022.12.16-ний өдрийн 13/69 дугаар тогтоолоор нийт 2,162,575.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №10. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	154,428,5	90,695,2	63,733.3
Засаг даргын Тамгын газар	490,321,2	509,726,3	19,405.1
Сургууль	166,222,2	128,796,1	37,426.1
Цэцэрлэг	58,664,6	46,006,1	12,658.5
Эрүүл мэндийн төв	46,035,3	30,475,7	15,559.6
Соёлын төв	33,229,0	29,550,5	3,678.5
Сум хөгжүүлэх сан		91,159,0	91,159.0
Орон нутгийн хөгжлийн сан		1,236,167,0	1,236,167.0
<b>Нийт дүн</b>		<b>2,162,575,9</b>	<b>2,162,575.9</b>

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.16-ний өдрийн 13/69 дугаар тогтоолоор анх 2,162,575.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.07-ний өдрийн 17/86 дугаар тогтоолоор 185,625.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Нийт зардлын 674,560.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 609,919.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 296,100.0 мянган

төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 136,441.7 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 464,269.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс, 42,229.0 мянган төгрөгийг хоршоог хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс, 75,350.0 мянган төгрөгийг хандив тусламжийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 609,919.9 мянга, орон нутгийн орлогоос 341,385.7 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 657,292.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 473,139.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,751.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 89,314.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №11. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	630625,9	573844,6	56781,3	91	122041,7
ИТХ	112807,3	94804,7	18002,6	84	14400,0
Соёлын төв	29550,5	21669,9	7880,6	73	0
Сум хөгжүүлэх сан	91159,0	70000,0	21159,0	76	-
Сургууль	132796,1	131008,3	1787,8	97	0
Цэцэрлэг	46006,1	43441,2	2564,9	94	0
ЭМТ	31675,7	29229,7	2446,0	94	0
ОНХС	1274180,6	103315,0	240985,6	81	
Нийт дүн	2348801,2	1997193,4	351607,8	85	136441,7

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн зөрүү 56,781.3 мянган төгрөг буюу 85 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 56,781.3 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 18,002.6 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 240,985.6 мянга, тусгай зориулалтын байгууллагуудын байр ашиглалтын зардлаас 14,679.3 мянга, хоршоог хөгжүүлэх сангийн зардлыг 21,159.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 1,300.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 233,382.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 186,811.6 мянган төгрөгийг зарцуулж, 47,871.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 12. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,300.0	233,382,6	234,682,6
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0		1300,0
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		233,382,6	233,382,6
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,300.0	185,514,6	186,811,6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,297,0	185,514,6	186,811,6
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,0	47,868,0	47,871,0
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	0.0	0.0	47,871,1

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж ахлах аудитор М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн 1/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Идэрмөнх, 2 дугаар гарын үсгийг Санхүүгийн албаны дарга Г.Дүүрэнбилэг нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 1,749,775.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,497.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,248.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 133 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 115 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

#### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчил илэрснээс 21,909.6 алдаа зөрчлийг давтан гаргахгүй 2 зөвлөмж<sup>1</sup>, албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 1/83 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	19,042.7	1	19,042.7			100.0
Зөвлөмж	2	0	1	0			100.0
Нийт	3	19,042.7	1	19,042.7			100.0

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 33,550.0 мянган төгрөгөөр баталж 19,758.4 мянган төгрөгийг зарцуулж 13,791.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### 4.9 Аудитын гол асуудал

Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 296,100.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төсвөө баталснаар 468,191.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 158,1 хувьтай биелүүлсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа 3 байгууллагын санхүүгийн тайлангаас ЗДТГ-ын санхүүгийн тайланг дүгнэлтээр, бусад 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан, санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл			
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Зөрчилгүй	Үүнээс	
Бие дааж дүгнэлт гаргасан			Түүвэрт хамруулсан	Хязгаарлалттай			Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1	1			1		
ИТХурал	1	1			1			
ОНХС	1	1			1			
СХС	1	1			1			
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 365,659.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,264.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 233,463.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага өгч, 130,931.1 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

**Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
<b>ЗДТГ</b>	6	15,814.1	-	-	3	1,264.5	2	9,586.1	1	6,587.5
<b>ОНХСан</b>	3	124,343.6	-	-	-	-	-	-	3	124,343.6
<b>СХС</b>	2	161,030.0	-	-	-	-	2	161,030.0	-	-
<b>СТА зөрчлийн дүн</b>	11	301,187.7	-	-	3	1,264.5	4	170,616.1	4	130,931.1
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
<b>ЗДТГ</b>										
<b>ОНХСан</b>	1	62,847.8					1	62,847.8		
<b>ИТХурал</b>										
<b>Нийцлийн аудитын дүн</b>	1	62,847.8					1	62,847.8		
<b>Нийт дүн</b>	12	365,659.5			3	1,264.5	5	233,463.9	4	130,931.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 301,187.7 мянган төгрөгийн 11 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 62,847.8 мянган төгрөгийн 1 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
<b>Засаг даргын Тамгын газар</b>		<b>15,814.1</b>			
1	Байгууллагын төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн хорголжин тэжээлийг малчдад тараасан анхан шатны баримтад 79 малчдад тараасан байхад 100 малчин өрхөд олгосноор зарлагдсан байна.	1,050.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг
2	Малчид, төлчдийн зөвлөгөөнд олгосон 1,195.0 мянган төгрөгийн шагнал, мал тооллогын урамшуулалд олгосон 450.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	164.5	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг
3	Санхүүгийн тайлангийн завсарын аудитаар бараа материалыг түүвэрлэн биет тооллого хийхэд 45.0 мянган төгрөгийн бал, 5.0 мянган төгрөгийн дэвтэр дутагдсан.	50.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг
4	Баян-Өндөр сумын 100 жилийн ойг 2023 оны 07 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд тэмдэглэж, "Бай баян өндөр" хоршоонд 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр тус ойн арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөгийг олгосон байхад санхүүгийн баримтад анхан шатны баримт байхгүй, байгууллагын үндсэн төсвөөс ойн арга хэмжээний зардалд 3,012.2 мянган төгрөгийн зардлыг олгохдоо холбогдох шийдвэрийг гаргаагүй байна.	8,012.1	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг

**Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгааг тус байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан газартай тулган шалгахад Баян-Өндөр сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон ус түгээх цэгийн газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 72 дугаар тогтоолоор хуучин ЗДТГ-ын барилгыг газрын хамт дуудлага худалдаагаар худалдсан байхад 1,574.0 мянган төгрөгийн өртөг бүхий тус газрыг бүртгэлээс хасаагүй байна.	1,574.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг
6	Байгууллагын төсвийн захирагч урсгал засварын зардал, сэлбэг хэрэгсэл худалдан авах шийдвэрийг гаргаагүй, автомашинд олгож байгаа сэлбэг хэрэгслийг автомашины хувийн хэрэгт бүртгээгүй байна.	6,587.5	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр Б.Уранчимэг
<b>Сум хөгжүүлэх сан</b>		<b>161.030.0</b>			
1	Хоршоо хөгжүүлэх сангаас 2022-2023 онуудад олгосон 8 зээлдэгчийн 160,000,000 (Нэг зуун жаран сая) төгрөгийн зээлийн гэрээний хавсралт зээлийн эргэн төлөлтийн хуваарийг жилд 1 удаа төлөхөөр байгуулсан байна.	160,000.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Идэрмөнх Г.Бадмаа
2	Хоршоо хөгжүүлэх ангаас зээл авсан иргэн, хоршооноос авах авлага зээлдэгч Э.Ариунцэцэгийн авсан 1,030,000 (Нэг сая гучин мянган) төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна.	1,030.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Идэрмөнх Г.Бадмаа
<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>		<b>124.343.6</b>			
2	Баян-Өндөр сумын ОНХС-аас хийгдсэн "Спортын залны гадна, дотор тохижилт" ажлыг 20,000,000 төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр 2023.03.01-ны өдөр гэрээ байгуулж ажил гүйцэтгэгдсэн боловч 2023.12.18-ны өдөр ажлын гүйцэтгэлтэй танилцахад спорт заалны будаг ховхорсон, бүргэд хаалганы бариул эвдэрсэн, сагсны шийдны 2 талд байрлуулсан гэрэл стандартын шаардлага хангахгүй байгаагаа ажилуулаагүй зэрэг алдаа илэрсэн.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Идэрмөнх Г.Бадмаа
3	Баян-Өндөр сумын ОНХС-аас хийгдсэн "Наадмын талбайн сандал засах засварлах" ажлын 104,343,565 төгрөгөөр ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 2023.07.28-ны өдөр ажлын хэсэг хүлээн авсан байна.	104,343.6	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Идэрмөнх Г.Бадмаа
	Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Цэцэрлэгт хүрээлэнгийн засварын ажлыг хийж гүйцэтгэх" 20,000,000.0 (Хорин сая) төгрөгийн ажлыг иргэн Ц.Манлайбаатараар гүйцэтгүүлэхээр ажил гүйцэтгэх гэрээг байгуулж 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөхөөр харилцан тохиролцсон боловч одоог хүртэл ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөөгүй байна.	20,000.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Идэрмөнх Г.Бадмаа
<b>Нийт дүн</b>		<b>301.187.7</b>			

**5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

oOo